



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах
зөвлөлийн гаргасан дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн
удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. 2022 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг
хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг
болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ХУЛАН



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
гаргасан дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. 2022 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангах, 2021 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилах чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулан толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ХУЛАН



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийн цалин, урамшууллын
хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, ““Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөллийг охин болон хараат компанид хэрэгжүүлэх тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.3 дахь заалтууд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар баталсан удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



О.ХУЛАН